



СОЙЕМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№01 /215/

2022.01.03

Цахим шууданд

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД ШИНЭ ЖИЛИЙН БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 032 дугаар анги Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын шинэ жилийн баярын өдрийн зоогт ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр, Цэргийн аюулгүй байдлын төлөвлөлтийн мэргэжилтэн хошууч Г.Азаяа нар хүрэлцэн ирж, шинэ жилийн баярын мэндчилгээ дэвшүүлж, айлчлан ирж буй 2022 онд ажил үйлс, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөгөөд цэргийн албаа үлгэр жишээ хааж буй хугацаат цэргийн алба хаагчдад

гарын бэлэг гардууллаа.

Шинэ жилийн гарын бэлгийг ангийн 2021 оны "Тэргүүний дэд түрүүч" ХХТР-ын дэд түрүүч Б.Эрдэнэдаваа, "Тэргүүний байлдагч" ХҮТР-ын байлдагч Б.Төрболд ХХТР-ын байлдагч Г.Лха-Очир, Н.Цогмагнай, О.Отгонбаяр, Г.Хангай, Б.Жигмэд, ХҮТР-ын байлдагч Б.Тэмүүжин, Г.Түвшинтөгс, Х.Мөнхзул нар гардан авлаа.

Мөн энэ үеэр сар бүр уламжлал болгон зохион байгуулдаг хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийн баярыг дурсгалын зүйл, урлагийн хэсэгчилсэн тоглолттойгоор зохион байгуулсан юм.

ӨВЛИЙН ӨВГӨН, ЦАСАН ОХИДТОЙ ШИНЭ ЖИЛИЙН ҮДЭШ



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын шинэ жилийн баяраа оны сүүлийн өдөр зохион байгууллаа. Хугацаат цэргийн алба хаагчдын шинэ жилийн баярт ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Г.Хатанбаатар, захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга хошууч Д.Мөнхбаатар нар оролцсон юм.

энэхүү баярт ХХТР-ын байлдагч Х.Алтанбагана морин хуурын хөг аялгуугаар дайчдын сонорыг мялааж, ахмад Б.Мөнхбат, ахлах ахлагч Б.Эрдэнэбаатар, ХҮТР-ын дэд түрүүч Ю.Гүррагчаа, Э.Мөнхбаясгалан нар ая дууны мэндчилгээ дэвшүүлээ.

Өвлийн өвгөн, цасан охидтойгоо айлчлан ирж, шинэхэн дайчдад баярын бэлэг гардуулснаас гадна хугацаат цэргийн алба хаагчдыг ар гэрийнхэнтэй нь цахимаар уулзуулж, баярын мэндчилгээ дэвшүүлсэн нь тэдний хувьд баяр дээр баяр нэмсэн үйл явдал боллоо.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2.266.151 /69.7%/	2,164.925 /66.5%/	917.048 28,2%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7190 +112	352	6710

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАА ЭРГЭЛЭЭ



Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Тус цэргийн штаб нь жил бүр хугацаат цэргийн алба хаагчдаа эргэдэг уламжлалтай билээ. 2021 оны II ээлжээр Сүхбаатар аймгийн Онгон суманд байрлах Хилийн цэргийн 0184 дүгээр ангид алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчдынхаа

ахуй нөхцөл, албаны үйл ажиллагаатай танилцаж, хүн нэг бүртэй уулзахын зэрэгцээ ар гэрээс нь илгээсэн захидал, илгээмж, гарын бэлгийг гардуулан өглөө. Шинэ оны босгон дээр тохиосон энэхүү эргэлт нь хугацаат цэргийн алба хаагчдад гэнэтийн бэлэг болсон юм.

Ахмад Д.НЯМЧУЛУУН

“ЖАРГАЛТАЙ ШИНЭ ЖИЛ” БАЯРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Тус ангийн хугацаат цэргийн алба хаагчдын “Жаргалтай шинэ жил” баярын үйл ажиллагааг зохион байгууллаа. Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цомхон байдлаар тэмдэглэн энэхүү баярын үйл ажиллагаанд ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар, захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Л.Чинзориг, захирагчийн орлогч-ерөнхий инженер дэд хурандаа Б.Ганбаатар, ангийн ахлагч, тэргүүн ахлагч Н.Мянгат болон Инженер сапёрын батальоны

удирдлага бие бүрэлдэхүүн оролцсон юм.

“Жаргалтай шинэ жил” баярын үеэр алба, салбаруудын дэмжлэгтэйгээр хугацаат цэргийн алба хаагчдын дунд 2021 оны аэтан шалгаруулах сугалаа зохион байгуулж, байлдагч Ө.Нурсултан, Б.Өнөмөнх, О.Тэмүүлэн, Б.Тэмүүгэн, О.Баттулга, О.Мөнхдөл, Х.Баяржавхлан, Б.Еркебулан, Б.Билгүүндалай нар бэлэг хожсон бол “Шилдгийн шилдэг аэтан”-гаар байлдагч Б.Гантогтох тодорч, 2022 оны аз, од дагуулсан гарын бэлэг гардан авлаа.

Лүргэлжлэл нь арын нүүрт!

Түүхэнд энэ өдөр

1995 он.

Батлан хамгаалах сайдын тушаалаар “Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын цэргийн жинхэнэ алба хаах дүрэм”-ийг батлав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-13	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,846.0	2,851.0
EUR	3,227.0	3,238.0
CNY	431.00	436.10
RUB	36.80	39.30
JPY	24.65	24.85
KRW	2.38	2.39

ЗУРХАЙ

2022.01.03 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 1/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ
УЛААН ЛУУ ӨДӨР ЭЛДЭВ
ТЭНГЭРТЭН ОДТОЙ, УЛААН
ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.42-17.11

Барилдлага: Идэр

Шүтэн барилдлага: Мунхрахуй

Суудал: Гал

Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн.

Гүүр тавих, газар ухах, эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 290,632,901

Эдгэрсэн

Нийт: 254,530,059

Нас барсан

Нийт: 5,460,317

“ЖАРГАЛТАЙ ШИНЭ ЖИЛ” БАЯРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

/түрүүч нь эхний нүүрт/



Мөн “Жаргалтай шинэ жил” цахим мэндчилгээний уралдааныг ирүүлсэн бүтээлүүдийг ангийн болон “Сапёрчин дайчид-2021” эцэг эхчүүдийн цахим хуудсанд байршуулан зохион байгуулснаас “Ус

хангалтын рот”-ын хамт олны мэндчилгээ 132 лайк, 227 комментоор Тэргүүн байрт шалгарч, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнуулав. Баярын дараа дайчид үдшийн зоог барьж, “Цэрэг эрсэд хүргэх таны илгээмж” аяны хүрээнд цэргийн ар гэрээс ирүүлсэн баярын бэлгээ хүлээн авч нэгэн үдшийг аз жаргалтайгаар өнгөрүүлсэн юм. Энэхүү хугацаат цэргийн алба хаагчдын шинэ жилийн баярын үйл ажиллагааг цахимаар шууд хүргэсэн нь цэргийн ар гэр, хайртай дотны хүмүүст нь тун их таалагдлаа.

Дэслэгч Р.БИЛЭГ

БАЙЛДАГЧ ААВТАЙ ХҮҮХДҮҮДИЙГ НЬ ЦАХИМААР УУЛЗУУЛАВ



Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын удирдлага шинэ жилийн баярыг тохиолдуулан 2021 оны II ээлжээр Зэвсэгт хүчний 327 дугаар ангид хугацаат цэргийн албанд татагдан алба хааж буй байлдагч, хоёр хүүхдийн аав Т.Мөнгөншагайн ар гэрт хүнсний бараа бүтээгдэхүүн, хүү М.Мөрөн, охин М.Мишээл нарт шинэ жилийн бэлэг гардуулан өглөө. Мөн шинэхэн байлдагчийг ар гэрийнхэнтэй нь цахимаар уулзуулж, шинэ оны баярын үеийн сэтгэгдлийг нь хуваалцсан нь иргэн-цэргийн харилцааг бэхжүүлсэн чухал үйл ажиллагаа боллоо.

НАЙМАН СУРГАГЧ БАГШ “БОР БҮС” ХҮРТЛЭЭ



Зэвсэгт хүчний гардан тулааны сургагч багш нарыг мэргэшүүлэх Шинкиокушинкай каратэгийн 45 хоногийн эрчимжүүлсэн, бүс зэрэглэл олгох дамжаа ЗХЖШ-ын даргын тушаалаар зохион байгуулагдаж, Зэвсэгт хүчний 20 анги, байгууллагын төлөөлөл 20 сургагч багш хамрагдлаа. Бие бялдрын төдийгүй ёс зүйн төлөвшилийг олгодог, бүх тулааны урлагийн суурь болсон эл спорт нь 10 бүсний

зэрэглэлтэй бөгөөд энэхүү анхны сургалтад оролцогчид бүгд олон улсын шалгалт авах болзлыг хангаснаас гадна 8 сургагч багш бор бүс, 2 кю зэрэгтэй төгссөн бол бусад нь ногоон бүс, 3 кю хүртсэн гайхалтай амжилт үзүүлжээ.

Д э л х и й н Шинкиокушинкай каратэгийн хар бүс, I дантай, “Арми” клубийн багш бэлтгэл ахлах ахлагч П.Дарханбаатар “Зэвсэгт хүчний гардан

тулааны тэмцээн хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг ч ихэвчлэн спортын зэрэг, цолтой мэргэжлийн цөөн тамирчид оролцдог. Харин бид нийтийг хамарсан байдлаар бие хамгаалах, тулааны урлагийг дэлгэрүүлэхийг зорьж байна. Энэхүү сургалтыг бид цаашид үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, цэрэг дайчдад зориулан зохион байгуулна” гэлээ.



2021 ОНЫХОО ОЛОЛТ АМЖИЛТАА ДҮГНЭЖ, ТЭРГҮҮНИЙ АЛБА ХААГЧДАА ТОДРУУЛЛАА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн бие бүрэлдэхүүн 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаа дүгнэж, оны сүүлийн өдөр баярын хурлаа зохион байгуулж, ажил үйлсээрээ манлайлсан алба хаагчдаа хүндэтгэл үзүүлж, таван номинациар тэргүүний хамт олон, алба хаагчийг шалгаруулан шагнал гардууллаа.

Тус ангийн захирагч, хурандаа У.Буянжаргал баярын хурлыг нээж хэлсэн үгэндээ “Улиран одож буй он цагийн хэлхээнд амжилт бүтээлээ хэлэлцэн дүгнэж, ирж буй 2022 ондоо хийж бүтээх зорилго, зорилтыг өвөрлөн, сэтгэл өөдрөг суугаа Монгол Улсын батлан хамгаалах салбарт хамтран зүтгэж буй нийт офицер, ахлагч, ажилтан алба хаагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч та бүхэндээ аз жаргал, эрүүл энхийг хүсэн

мэндчилж байна. Тус анги нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн цэргийн сургалт, бэлтгэлийг эрчимжүүлэн ажилтан алба хаагчдынхаа нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилт тавин ажиллалаа. Бид энэхүү зорилтынхоо хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн алба хаагчдынхаа ур чадвар, мэргэжлийн боловсон хүчинд суурилсан чадварлаг хамт олныг бэлтгэн хөгжүүлж, хугацаат цэргийн алба хаагчдын сургалт, дамжааг эрчимжүүлэн тэдгээрт БХЯ, ЗХЖШ, БЦУГ-ын төрийн бодлогын хэрэгжилтийг ханган, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэж, ажиллах таатай орчныг бүрдүүлэх зэрэг бодлого чиглэл баримтлан ажиллах болно” гэж онцлон дурдсан юм.

Ангийн “2021 оны Тэргүүний хамт олон”-оор ахлах дэслэгч Н.Батжаргал

дэргатай Үйлдвэрлэл, маркетингийн хамт олон, “2021 оны Тэргүүний салбар”-аар ахлах ахлагч Р.Мөнхзул захирагчтай Материал хангалтын салбарын авто тээврийн салаа, “2021 оны Тэргүүний офицер”-оор Ажиллагааны удирдлагын тасгийн дарга, ажиллагааны ахлах офицер, ахмад Б.Ууганбаатар, “2021 оны Тэргүүний ахлагч”-аар Дайчилгааны нууцан хэрэг хөтлөгч, ахлах ахлагч Ч.Бат-Эрдэнэ, “2021 оны Тэргүүний ажилтан, албахаагч”-аар Ахуй үйлчилгээний төвийн хувцас засварчин Г.Наранцэцэг нар тус тус шалгарлаа. Мөн 2021 оны Ангийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээний тэргүүн байрын баг, тамирчдад өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал гардуулснаас гадна алба хаагч бүр астан болох “Супер хонжворын сугалаа” зохион байгуулсан нь шинэлэг, сонирхолтой үйл явдал болсон.

ХАЙР ДҮҮРЭН ҮДИЙН ЗООГИЙГ ХАМТДАА БАРИЛАА

Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн оны сүүлийн гурван өдөр хугацаат цэргийн алба хаагчдаа хүндэтгэл үзүүлж, “Шинэ жил-2021”, “Төрсөн өдөр”-ийн баярыг шинэлэг байдлаар зохион байгууллаа. Энэхүү баярт ангийн захирагч хурандаа У.Буянжаргал, захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Д.Галбадрах, захирагчийн орлогч-ерөнхий инженер хошууч М.Гончигсум, ангийн ахлагч, тэргүүн ахлагч Г.Гантулга болон Барилга угсралт засварын рот, Инженер сапёрын ротын бүрэлдэхүүн оролцсон юм. “Шинэ жил-2021” баярын цэнгүүний үеэр хугацаат цэргийн алба хаагч бүр астан болсноос гадна “Супер астан”, “Дэд байрын астан”, “Тусгай байрын астан” шалгаруулсан бөгөөд “Супер астан”-гаар Инженер сапёрын ротын II салааны байлдагч Э.Батцоож тодорлоо.



Мөн 12 дугаар сард төрсөн нэр бүхий 15 байлдагчийн Төрсөн өдрийн баярыг зохион байгуулж, ангийн захирагч хурандаа У.Буянжаргал, захирагчийн зөвлөлийн гишүүд тэдэнтэй нэг ширээнд сууж, цэргийн алба болон ирээдүйн хүсэл зорилго, хувь хүний хөгжил, манлайллын талаар харилцан яриа өрнүүлж, хүндлэл, хайр

дүүрэн үдийн зоогийг хамтдаа бариллаа. Энэ үеэр ахлах дэслэгч Б.Баасанжав даргатай Үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн дэлхийн алдартай сонгодог зохиолуудыг үлээвэр найрал хөгжимд эгшиглүүлж байсан нь хугацаат цэргийн алба хаагчдын урлагийн гоо зүйн мэдлэгийг дээшлүүлсэн явдал болсон юм.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

